



**БАЯНГОЛ ДҮҮРГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ**

2018 оны 02 сарын 19 өдөр

Дугаар А/60

Улаанбаатар хот

**“Мөнгөн Улаанбаатар” өвлийн спорт
наадамд оролцох тухай**

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.5.а, 29.2, нийслэлийн Засаг даргын 2018 оны А/23 дугаар захирамж, Нийтийн биеийн тамир, спортын хорооны 02/34 дүгээр албан бичиг, удирдамжийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Нийслэлийн төр захиргааны байгууллагын ажилтан, албан хаагчдын “Мөнгөн Улаанбаатар” өвлийн спорт наадмын “Цасны баяр” арга хэмжээнд дүүргийн харьяа хэлтэс, албадыг зохион байгуулалттай оролцуулсугай.

2. Өдөрлөгт оролцох удирдамжийг нэгдүгээр, оролцох багийн бүрэлдэхүүнийг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

3. Тус өвлийн өдөрлөгт нийт ажилтан албан хаагчдыг бүрэн хамруулж, нийтийн биеийн тамир, спортыг сурталчлан ажиллахыг Нийгмийн хөгжлийн хэлтэс, /А.Одонтунгалагтуул/, Биеийн тамир, спортын хороо /Б.Дамба/-нд тус тус үүрэг болгосугай.

4. Арга хэмжээнд шаардагдах төсвийг хууль тогтоомжийн хүрээнд баталж, холбогдох зардлын данснаас гаргахыг Тамгын газар /Д.Дэлгэрмаа/-т зөвшөөрсүгэй.

5. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж, үр дүнг тооцож ажиллахыг Засаг даргын орлогч Г.Нарангэрэлд даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



С.ОДОНТУЯА